Posters

Funded by the European Union

Food and Agriculture Organization of the United Nations

International Labour Organization

# [2021 Awareness Raising Campaign on Labour Rights of Youth in Mongolia]

АЖИЛ БОЛ...

ЗАЛУУЧУУДАД ХӨДӨЛМӨРЛӨХ ЭРХИЙН МЭДЛЭГ ОЛГОХ СОШИАЛ АЯН


ЭНЭ БОЛ ДАВАА.
35 НАСТАЙ.
Мянгат малчин айлд туслах малчнаар гэрт нь байрлаж ажилладаг
АЖИЛ БОЛ
ЗОХИСТОЙ
БАЙХ ЁСТОЙ
DECENT JOBS FOR YOUTH
DECENT WORK FOR YOUTH
Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага


ДАВАА МЯНГАТ МАЛЧНЫ 1500 ТОЛГОЙ МАЛЫГ 2 ЖИЛИЙН ХУГАЦААНД МАЛЛАЖ САРДАА 800.000 ТӨГРӨГ АВЧ БАЙХААР ТОХИРЧЭЭ.
АЖИЛЛААД ЖИЛ БОЛОХДОО АМРАЛТ АВЧ ҮЗЭЭГҮЙ, ӨДӨР БҮР МАЛ МАЛЛАДАГ БОЛЖЭЭ.
АЖИЛ ОЛГОГЧ НЬ ЗАРИМДАА БЭЛЭН МӨНГӨ БАЙХГҮЙ ГЭЭД ДАВААГИЙН ЦАЛИНГИЙН ТАЛД НЬ 1 ХОНЬ ТООЦОЖ ОЛГОДОГ.
ИНГЭЖ БОЛОХ УУ?
ХӨДӨЛМӨРИЙН ХУУЛЬТАЙГАА БҮРЭН ТАНИЛЦАЖ,
ЭРХЭЭ ХАМГААЛААРАЙ!
АЖИЛ БОЛ
АЖИЛТНЫ ХӨДӨЛМӨРИЙГ ШУДАРГААР ҮНЭЛДЭГ
БАЙХ ЁСТОЙ


ЭНЭ БОЛ ХУЛАН.
ТЭР 18 НАСТАЙ
ОЮУТАН.
Хичээлийн бус цагаараа ажил хийдэг
АЖИЛ БОЛ
ЗОХИСТОЙ
БАЙХ ЁСТОЙ
DECENT JOBS FOR YOUTH
DECENT WORK FOR YOUTH
Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага


ХУЛАН ХИЧЭЭЛЭЭ ТАРААД НЭГЭН АЙЛД ТОГТМОЛ ЦЭВЭРЛЭГЭЭ ХИЙЖ БАЙХААР БОЛЖЭЭ.
АЙЛЫН ЭЗЭН ГЭР ЦЭВЭРЛЭХЭД ГЭРЭЭГЭЭР ЯАХАВ, ЧИ Л АЖЛАА САЙН ХИЙГЭЭД БАЙВАЛ БИД ЧАМАЙГ АЖИЛЛУУЛААД Л БАЙНА. ГЭРЭЭР ИРЖ БАЙГАА ЮМ ЧИНЬ ИРГЭНИЙ ҮНЭМЛЭХЭЭ НАДАД ХАДГАЛУУЛААРАЙ ГЭЖЭЭ.
АЖЛЫН ХӨЛСИЙГ 2 ДОЛОО ХОНОГ ДУТАМДАА ТООЦОЖ ОЛГОНО ГЭСЭН БОЛОВЧ САРЫН СҮҮЛЭЭР БОЛЬЁ ГЭЭД ХОЙШЛУУЛААД ОДОО ХҮРТЭЛ ӨГӨӨГҮЙ БАЙГАА.
ИНГЭЖ БОЛОХ УУ?
ХӨДӨЛМӨРИЙН ХУУЛЬТАЙГАА БҮРЭН ТАНИЛЦАЖ, ЭРХЭЭ ХАМГААЛААРАЙ!
АЖИЛ БОЛ
БАРЬЦАА ХЭРЭГЛЭХИЙГ
ХОРИГЛОНО


ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/:
• АЖИЛ ОЛГОГЧ ТУСЛАХ МАЛЧИНД ЭЭЛЖИЙН АМРАЛТ ОЛГОХ ҮҮРЭГТЭЙ. ТУСЛАХ МАЛЧИН ДОЛОО ХОНОГТОО ТАСРАЛТГҮЙ 24 ЦАГ, ТҮҮНЭЭС ДЭЭШ ХУГАЦААГААР АМРАХ ЭРХТЭЙ. (71.6-Р ЗҮЙЛ)
• ӨӨРӨӨ ЗӨВШӨӨРСӨН БОЛ ЦАЛИН ХӨЛСНИЙ 30-ААС ИЛҮҮГҮЙ ХУВИЙГ МӨНГӨН БУС ХЭЛБЭРЭЭР АВАХ БОЛОМЖТОЙ. (112.1-Р ЗҮЙЛ)
• МӨНГӨН БУС ХЭЛБЭРЭЭР ОЛГОХ БАРАА БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНЭ ЗАХ ЗЭЭЛИЙН ДУНДЖААС ИЛҮҮГҮЙ БАЙХ ЁСТОЙ. ҮҮНД ТАМХИ, СОГТУУРУУЛАХ УНДАА, БҮХ ТӨРЛИЙН ЭМ, ХУУЛИАР ХОРИГЛОСОН ЭД ЗҮЙЛ, БАРАА БҮТЭЭГДЭХҮҮН БАЙХЫГ ХОРИГЛОНО. (112.3-Р ЗҮЙЛ)
• САЙН ДУРААРАА НИЙГМИЙН ДААТГАЛД ХАМРАГДАХ БОЛОМЖТОЙ. (71.8-Р ЗҮЙЛ)
• ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭГ ХЭРХЭН БАЙГУУЛАХ ТАЛААР СУМЫН ЗДТГ-Т ХАНДАН ЗӨВЛӨГӨӨ АВЧ, БИЧГЭЭР БАЙГУУЛАН БҮРТГҮҮЛНЭ. (70.1, 70.2-Р ЗҮЙЛ)
Хэрэв туслах малчин таны хөдөлмөрлөх эрх зөрчигдсөн бол сум, дүүргийнхээ хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хороонд хандана уу.
АЖИЛ БОЛ
АЖИЛТНЫ ХӨДӨЛМӨРИЙГ ШУДАРГААР ҮНЭЛДЭГ
БАЙХ ЁСТОЙ


АЖИЛ БОЛ...
ЗАЛУУЧУУДАД ХӨДӨЛМӨРЛӨХ ЭРХИЙН МЭДЛЭГ ОЛГОХ
СОШИАЛ АЯН
DECENT JOBS FOR YOUTH
DECENT WORK FOR YOUTH
Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага
ЗАЛУУЧУУДЫН ЗОХИСТОЙ ХӨДӨЛМӨРИЙН СҮЛЖЭЭНИЙ ГИШҮҮН БАЙГУУЛЛАГУУД


ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/:
• АЖИЛТАН АЖИЛ ҮҮРГЭЭ ГҮЙЦЭТГЭЖ ЭХЭЛСНЭЭР ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ХАРИЛЦАА ҮҮСНЭ. (41.2-Р ЗҮЙЛ)
• АЖИЛ ОЛГОГЧ НЬ ГЭРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖИЛТАН ТЭДГЭЭРТЭЙ АДИЛТГАХ АЖИЛТАНТАЙ ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭГ БИЧГЭЭР БАЙГУУЛНА. (71.1-Р ЗҮЙЛ)
• ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭГ АЙМАГ, ДҮҮРГИЙН ХӨДӨЛМӨРИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА, СУМАНД ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРААС ЗӨВӨЛГӨӨ АВЧ БҮРТГҮҮЛЖ БОЛНО. (70.1, 70.2-Р ЗҮЙЛ)
• АЖИЛ ОЛГОГЧ АЖИЛТНЫ ХУВИЙН БАРИМТ БИЧГИЙН ЭХ ХУВИЙГ ШААРДАН АВЧ БАРЬЦААЛАХЫГ ХОРИГЛОНО. (10.1-Р ЗҮЙЛ)
• ЦАЛИН ХӨЛСӨӨ ХУГАЦААНД НЬ ОЛГООГҮЙ ТОХИОЛДОЛД АЛДАНГИ ТООЦОЖ АВАХ ЭРХТЭЙ. МӨН ИЛҮҮ ЦАГААР АЖИЛЛАСАН ТОХИОЛДОЛД НЭМЭГДЭЛ ХӨЛС АВАХ ЭРХТЭЙ. (124.1, 109-Р ЗҮЙЛ)
• ГЭРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖИЛТАН САЙН ДУРААРАА НИЙГМИЙН ДААТГАЛ ТӨЛӨХ ЭРХТЭЙ. (71.8-Р ЗҮЙЛ)
Хэрэв таны хөдөлмөрлөх эрх зөрчигдсөн гэж үзвэл сум, дүүргийн хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хороонд гомдол гаргах эрхтэй.
АЖИЛ БОЛ
БАРЬЦАА ХЭРЭГЛЭХИЙГ
ХОРИГЛОНО


АЖИЛ БОЛ...
ЗАЛУУЧУУДАД ХӨДӨЛМӨРЛӨХ ЭРХИЙН МЭДЛЭГ ОЛГОХ
СОШИАЛ АЯН
DECENT JOBS FOR YOUTH
DECENT WORK FOR YOUTH
Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага
ЗАЛУУЧУУДЫН ЗОХИСТОЙ ХӨДӨЛМӨРИЙН СҮЛЖЭЭНИЙ ГИШҮҮН БАЙГУУЛЛАГУУД